



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/231

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь хэсэг, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 24 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулах Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүний хэрэгжилт үр, дүнгийн талаар баруун 6 аймгийн бүсчилсэн сургалт хэлэлцүүлэгт санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2 Үйл ажиллагааны зардалд зарцуулагдах 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугэй.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

C:/ My Documents A-4 doc

0020102100

